



*Хяналт шалгалт, зохицуулалтын газар
Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах чиглэл*

2022 ОНЫ Ш УЛИРЛЫН ӨРГӨДЛИЙН СУДАЛГАА

Улаанбаатар хот
2022 он



2022 оны III улирлын өргөдлийн судалгааны тайлан

АГУУЛГА

НЭГ. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА	2
1.1 Салбарын үзүүлэлтүүд.....	3
1.1.1 Үнэт цаасны зах зээл.....	3
1.1.2 Даатгалын салбар	5
1.1.3 Банк бус санхүүгийн байгууллага	8
1.1.4 Хадгаламж, зээлийн хоршоо	9
1.1.5. Бусад өргөдөл	10
ХОЁР. АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ	11

2022 оны III улирлын өргөдлийн судалгааны тайлан

НЭГ. ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН СУДАЛГАА

Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газар нь хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, санал дүгнэлт гарган хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг.

2022 оны III улирлын байдлаар албан бичгээр 360, цахимаар 123, Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвөөс 28, нийт 511 өргөдөл, гомдол ирүүлснийг хүлээн авч тайлант хугацаанд 495 өргөдлийг шийдвэрлэн хариу хүргүүлж, 16 өргөдөл хуулийн хугацаанд хянагдаж байна.


Утсаар болон ажлын байранд ирсэн 377 иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээлэл тус тус өгч ажилласан.

Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлыг дараах байдлаар шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 1. Нийт өргөдлийн тоо


№	Салбар	2020	2021	2022.III			
				Албан бичгээр	Цахим	ЗГОНХ 11-11 төв	Нийт
1	Даатгал	269	201	152	40	6	198
2	Үнэт цаас	130	143	100	9	3	112
3	ББСБ	90	84	70	33	10	113
4	ХЗХ	10	21	14	2	2	18
5	Бусад	-	26	22	41	7	70
	Нийт	499	475	360	123	28	511

График 1. Нийт ирсэн өргөдлийн харьцуулалт



2022 оны III улирлын өргөдлийн судалгааны тайлан

График 2. Нийт ирсэн өргөдлийн хэлбэр



Хороонд 2021 онд ирүүлсэн нийт өргөдөл, гомдлыг тоог өмнөх онтой харьцуулахад 4.9 хувиар буурсан, 2022 оны III улиралд нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын тоог өмнөх онтой харьцуулахад 7.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

1.1 Салбарын үзүүлэлтүүд

Тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгч, үнэт цаас гаргагч, хөрөнгө оруулагчдын хоорондын маргааныг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1.1-т тус тус заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд санхүүгийн зах зээл дээр үйл ажиллагаа эрхэлж буй үнэт цаас, даатгал, банк санхүүгийн байгууллагын үйлчлүүлэгч, хадгаламж, зээлийн хоршооны гишүүд болон иргэдээс Хороонд хандаж 2022 оны III улиралд ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээллийг дор сийрүүлэв.

1.1.1 Үнэт цаасны зах зээл

Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон ХК-тай холбоотой нийт 112 өргөдөл, гомдол ирүүлснээс 104 өргөдлийг шийдвэрлэж, 8 өргөдөл хуулийн хугацаанд хянагдаж байна.

Өргөдөл, гомдлыг товч утгаар нь ангилбал:

Хүснэгт 2. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой ирсэн өргөдлийн товч утга

№	Товч утга	2020	Эзлэх хувь	2021	Эзлэх хувь	2022.III			Нийт	Эзлэх хувь
						Албан бичиг	Цахим	11-11 төв		
1	Хувьцаа зөвшөөрөлгүй арилжаалсан	42	32.3%	40	14.2%	43	-	1	44	39.2%
2	Хувьцааны бүртгэл, дансны мэдээллийг шалгуулах	22	16.9%	20	21.4%	15	-	-	15	13.3%
3	Хувьцааны тоо өөрчлөгдсөн	11	8.5%	-	-	-	-	-	-	-
4	ХОЭБ	8	6.2%	14	17.9%	10	-	-	10	9%

2022 оны III улирлын өргөдлийн судалгааны тайлан


5	Хамтын сан	11	8.5%	6	10.7%	13	-	-	13	11.7%
6	ҮЦК, ХК-ийн үйл ажиллагаа	30	23.1%	57	17.9%	19	5	-	24	21.5%
7	Бусад	6	4.6%	6	17.9%	-	4	2	6	5.3%
	Нийт	130	100%	143	100%	100	9	3	112	100%

Хороонд үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон ХК-тай холбоотой ирүүлсэн өргөдөл, гомдлыг дараах байдлаар урьдчилан шийдвэрлэв.

График 3. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой ирсэн өргөдлийн харьцуулалт



График 4. Үнэт цаасны зах зээлтэй холбоотой ирсэн өргөдлийн хэлбэр



Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг үндэслэн “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК, “ҮЦТХТ” ХХК, үнэт цаасны компаниас баримт, тайлбар гаргуулан тусгай зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэж байна.

Тайлант хугацаанд үнэт цаастай холбоотой иргэдээс Хороонд ирүүлсэн өргөдөл, гомдлоос хувьцааны бүртгэл данс шалгуулах 13.3 хувь, хувьцааг харилцагчийн зөвшөөрөлгүй арилжсан 39.2

2022 оны III улирлын өргөдлийн судалгааны тайлан

хувь, ҮЦК, ХК-ийн үйл ажиллагаатай холбоотой 21.5 хувь, хамтын сантай холбоотой өргөдөл 11.7 хувийг тус тус эзэлж байна. Энэ төрлийн өргөдлийн тоо өссөн шалтгаан нь олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр хөрөнгө оруулалтын эрхийн бичиг, ягаан цэнхэр тасалбартай холбоотой асуудлыг шалгана, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд харилцагчдын их хэмжээний мөнгө тараагдаагүй төвлөрч байна гэх мэдээллийг олон нийтэд хүргэснээс үүдэн иргэдээс өмнө нь тухайн асуудлаар хандан Хорооноос албан бичгээр хариу өгсөн асуудлаар дахин хандах байдал нилээд байна.

Хувьцааг харилцагчийн зөвшөөрөлгүй арилжсантай холбоотой өргөдөл, гомдлоос хувьцаа худалдах захиалгын гэрээ болон бэлэн мөнгө хүссэн өргөдөл, мөнгө олгосон тайланд нэр бүхий иргэний гарын үсэг зурагдсан өргөдөл гомдол нилээд хувийг эзэлдэг бөгөөд гарын үсэг зурагдсан бол тухайн гарын үсгийг хуурамч эсэхийг эрх бүхий байгууллагаар тогтоолгох талаар зөвлөж, 2000 оноос өмнө тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер, дилерийн компани олдохгүй байгаа талаар, ХК-аас ногдол ашиг авахгүй байгаа болон татан буугдсан брокер, дилерийн компаниар дамжуулан арилжаалагдсан тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.20 дахь заалтыг буцаан хэрэглэх боломжгүй, гомдолд дурдсан асуудал нь тухайн үеийн хуулиар зөрчилд тооцогддоггүй байсан, зөрчлийн хэргийн хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн зэрэг шалтгааны улмаас зөрчлийн шинжгүй гэж үзэн гомдлыг хүлээн авахаас татгалзаж, уг асуудлаар хуулийн байгууллагад хандуулахаар урьдчилан шийдвэрлэсэн байна.

Үнэт цаастай холбоотой 1 иргэнээс зөрчлийн гомдол ирүүлснийг бүртгүүлэн хэрэг нээн хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, албан тушаалтныг 2,000,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж, торгуулийг төлүүлж, 2 иргэнд 51 сая төгрөгийг тус тус олгуулж шийдвэрлэсэн байна. Нэр бүхий 6 иргэний төвлөрсөн хадгаламжийн дансанд “Материалимпекс” ХК-ийн 680, “Ариг гал” ХК-ийн 31, “Сор” ХК-ийн 105 ширхэг хувьцааг тус тус байршуулсан. Мөн 1 иргэний “Эрдэнэс тавантолгой” ХК-ийн 1072 ширхэг хувьцааг олгуулж шийдвэрлэсэн байна.

1.1.2 Даатгалын салбар

Тайлант хугацаанд үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд болон ХК-тай холбоотой нийт 198 өргөдөл, гомдол ирүүлснээс 195 өргөдлийг шийдвэрлэж, 3 өргөдөл хуулийн хугацаанд хянагдаж байна.

Өргөдөл, гомдлыг товч утгаар нь ангилбал:

Хүснэгт 4. Даатгалтай холбоотой ирсэн өргөдлийн товч утга

№	Товч утга	2020	Эзлэх хувь	2021	Эзлэх хувь	2022.III			Нийт	Эзлэх хувь
						Албан бичиг	Цахим	11-11 төв		
1	Нөхөн төлбөр олгохоос татгалзсан	127	47.2%	133	66.2%	105	8	-	113	57%
2	Нөхөн төлбөр олголгүй удаасан	38	14.1%	21	10.5%	9	15	1	25	12.7%
3	Нөхөн төлбөрийг хасч олгосон	33	12.3%	22	10.9%	18	1	-	19	9.6%
4	Даатгалын хураамжийн маргаан	11	4.1%	1	0.5%	3	7	-	10	5%
5	Даатгалын хохирлын	60	22.3%	24	11.9%	17			31	15.7%

2022 оны III улирлын өргөдлийн судалгааны тайлан

үнэлгээ болон бусад						9	5		
Нийт	269	100%	201	100%	152	40	6	198	100%

График 5. Даатгалтай холбоотой ирсэн өргөдлийн харьцуулалт





График 6. Даатгалтай холбоотой ирсэн өргөдлийн хэлбэр



Тайлант хугацааны даатгалын өргөдөл, гомдлыг бүтээгдэхүүний төрлөөр нь ангилбал:

Хүснэгт 5. Өргөдөл гомдолд эзлэх даатгалын бүтээгдэхүүний төрөл

№	Даатгалын төрөл	2020	Эзлэх хувь	2021	Эзлэх хувь	2022.III			Нийт	Эзлэх хувь
						Албан бичиг	Цахим	11-11 төв		
1	Жолоочийн хариуцлагын даатгал	67	25%	23	11.5%	29	12	-	41	20.7%
2	Авто тээврийн хэрэгслийн даатгал	104	38.7%	64	31.8%	59	15	-	74	37.3%
3	Гэнэтийн ослын даатгал	41	15.2%	64	31.8%	28	1	4	33	16.6%
4	Хөрөнгийн даатгал /ипотек/	20	7.4%	15	7.4%	5	3	-	8	4.1%

2022 оны III улирлын өргөдлийн судалгааны тайлан

7	Хариуцлагын даатгал	3	1.1%	9	4.5%	2	1	-	3	1.5%
10	Зээлийн даатгал	11	4.1%	4	2.0%	4	-	-	4	2.1%
8	Санхүүгийн даатгал	-	-	2	1.0%	2	-	-	2	1.1%
8	Даатгалын хохирлын үнэлгээ болон бусад	16	6%	20	10.0%	17	8	2	27	13.6%
9	Орон сууц зээлдэгчийн эрсдэлийн даатгал	2	0.7%	-	-	-	-	-	-	0
10	Мал амьтдын даатгал	-	-	-	-	-	-	-	-	0
11	Ачаа, тээврийн даатгал	1	0.4%	-	-	6	-	-	6	3%
12	Хуримтлалын даатгал	-	-	-	-	-	-	-	-	0
13	Эрүүл мэндийн даатгал	1	0.3%	-	-	-	-	-	-	0
14	Агаарын хөлгийн даатгал	-	-	-	-	-	-	-	-	0
15	Итгэлцлийн даатгал	3	1.1%	-	-	-	-	-	-	0
	Нийт	269	100%	201	100%	152	40	6	198	100%

Хороонд 2022 оны III улирлын байдлаар ирүүлсэн даатгалтай холбоотой нийт өргөдөл гомдлын тоон мэдээллээс харахад хамгийн өндөр буюу 37.3 хувийг авто тээврийн хэрэгслийн даатгал, 20.7 хувийг жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, 16.6 хувийг гэнэтийн ослын даатгалтай холбоотой өргөдөл, гомдол эзэлж байна.

Ирсэн өргөдөл, гомдлын агуулгаас үзэхэд, даатгуулагч даатгалын тохиолдол гарсан үед тухайн тохиолдлыг нотлох, даатгагч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх зэрэг үүргээ биелүүлээгүй, даатгалын хураамжийг хуваарьт заасан хугацаанд нь төлөөгүй зэргээс үүдэн даатгалын нөхөн төлбөр авах боломжгүй байдал үүссэн байна.

Мөн даатгагчийн зүгээс иргэдийн мэдлэг мэдээлэл дутмаг байдлыг ашиглан үндэслэлгүйгээр нөхөн төлбөрийг хасч олгосон, даатгалын нөхөн төлбөр олгохдоо хууль тогтоомж болон гэрээнд заагаагүй аливаа шаардлага, хязгаарлалт тавих, бүлгийн хэлбэртэй даатгалын гэрээ байгуулахдаа даатгуулагчид бүтээгдэхүүний талаар танилцуулга хийгээгүй, зөвшөөрөл авалгүйгээр гэрээ хийх, даатгуулагчид танилцуулаагүй гэрээний нөхцөлийг өөрчлөх, гэрээнд заасан эрсдэлийн дагуу даатгалын тохиолдолд үүсч, гэрээнд нөхөн төлбөр олгохоор зохицуулагдсан байхад илт үндэслэлгүйгээр татгалзах, нөхөн төлбөр олгохгүй удаах, даатгуулагчдыг чирэгдүүлж, даатгалын гэрээнд даатгалын зүйлийн талаарх мэдээллийг зөрүүлж бичсэн зэрэг зөрчил дутагдал гаргасан байна.

Тайлант хугацаанд харилцагчийн хохирол барагдуулах талаар өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулан 51 иргэн, хуулийн этгээдэд 541,801,114.78 төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулахаар урьдчилан шийдвэрлэсэнээс, даатгагч 24 иргэн, хуулийн этгээдэд 174,364,333.7 төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулсан.

2022 оны III улирлын өргөдлийн судалгааны тайлан

1.1.3 Банк бус санхүүгийн байгууллага


Тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын үйл ажиллагаатай холбоотой бичгээр 70, цахимаар 33, 11-11 төвөөр дамжиж 10, нийт 113 өргөдөл, гомдол ирснээс 112 өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, 1 өргөдөл хуулийн хугацаанд хянагдаж байна. Өргөдөл, гомдлыг товч утгаар нь ангилбал:

Хүснэгт 6. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой ирсэн өргөдлийн товч утга

№	Өргөдөл гомдлын товч утга	2020	Эзлэх хувь	2021	Эзлэх хувь	2022.III			Нийт	Эзлэх хувь
						Албан бичиг	Цахим	11-11 төв		
1	Зээлийн мэдээллийн сангийн мэдээлэл	29	32.2%	40	47.6%	22	13	2	37	32.7%
2	Зээл болон хүүгийн тооцоолол	-	-	7	8.3%	11	7	1	19	16.8%
3	Барьцааны зүйл чөлөөлүүлэх	-	-	2	2.4%	4	4	1	10	8.8%
4	Зээлийн гэрээний маргаан	20	22.2%	4	4.8%	-	-	-	-	-
5	ББСБ-ын үйл ажиллагаа	25	27.8%	20	23.8%	9	6	-	15	13.2%
6	Лавлагаа	12	13.3%	5	6.0%	4	-	-	4	3.5%
7	Бусад	4		6	7.1%	20	3	6	28	25%
	Нийт	90	100%	84	100%	70	33	10	113	100%


Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотойгоор ирүүлсэн өргөдөл, гомдлын дийлэнхийг буюу 32.7 хувийг зээлийн мэдээллийн сангийн мэдээлэлтэй холбоотой, 16.8 зээл болон хүүгийн тооцоололтой холбоотой, 13.2 хувийг ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой, 8.8 хувийг барьцааны зүйл чөлөөлөх, 3.5 хувийг лавлагаа, үлдсэн 25 хувийг бусад өргөдөл гомдол тус тус эзэлж байна. Зээлийн гэрээний маргаантай холбоотой өргөдлийг өмнөх онтой харьцуулахад 100% буурсан үзүүлэлттэй байна.

График 7. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой ирсэн өргөдлийн харьцуулалт



2022 оны III улирлын өргөдлийн судалгааны тайлан

График 8. ББСБ-ын үйл ажиллагаатай холбоотой ирсэн өргөдлийн хэлбэр



Зээлийн мэдээллийн сангийн мэдээлэлтэй холбоотой гомдол дийлэнх хувийг эзэлж буй шалтгаан нь иргэд зээлээ төлөөгүй хугацаа хэтрүүлсэн, өөрсдийн мэдлэг мэдээлэл дутмаг байдлаас зээл хойшлуулах хүсэлтээ тухай банк бус санхүүгийн байгууллагад албан ёсоор хүргүүлээгүйн улмаас маргаан үүсч, зээлийн мэдээллийн санд муу зээлдэгчээр бүртгэгдсэн байна. Мөн дээрх байдал нь иргэдийн авсан зээлийн чанар муудахад нөлөөлсөн байна.

Тайлант хугацаанд иргэдийн хохирлыг барагдуулах чиглэлээр 4 иргэний зээлийн мэдээллийн сан дахь мэдээллийг засуулсан, 3 иргэний барьцаа хөрөнгийг чөлөөлүүлсэн, 1 иргэний зээлийн дүнгийн алдааг засуулсан байна.

1.1.4 Хадгаламж, зээлийн хоршоо

Тайлант хугацаанд Хадгаламж, зээлийн хоршоо (ХЗХ)-дын үйл ажиллагаатай холбогдуулан Хороонд нийт 18 өргөдөл, гомдол ирснийг хуулийн хугацаанд хянан шийдвэрлэсэн байна.

Хүснэгт 7. ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн өргөдлийн товч утга

№	Товч утга	2020	Эзлэх хувь	2021	Эзлэх хувь	2022.III			Нийт	Эзлэх хувь
						Албан бичиг	Цахим	11-11 төв		
1	Лавлагаа гаргуулах	3	30%	3	14%	3	-	-	3	19.9%
2	Хадгаламж буцаан олгоогүй	-	-	1	5%	1	2	2	5	26.7 %
3	ХЗХ-дын үйл ажиллагаа	7	70%	7	33%	4	-	-	4	26.7%
4	Бусад	-	-	10	48%	6	-	-	6	26.7%
	Нийт	10	100%	21	100%	14	2	2	18	100%

2022 оны III улирлын өргөдлийн судалгааны тайлан

График 9. ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой ирсэн өргөдлийн харьцуулалт





График 10. ХЗХ-дын үйл ажиллагаатай холбоотой ирсэн өргөдлийн харьцуулалт



1.1.5. Бусад өргөдөл


Хүснэгт 8. Бусад өргөдлийн товч утга

№	Салбар	2022.III			Нийт
		Албан бичгээр	Цахим	11-11 төв	
1	Лавлагаа гаргуулах тухай	10	-	-	2
2	Ломбардны тухай	7	12	-	10
3	ТГҮМТГ тухай хууль зөрчсөн	3	1	1	2
4	Зохицуулалтгүй байгууллага шалгуулах тухай	1	1	-	3
5	Үл хөдлөх хөрөнгө, үнэт метал	-	2	-	1
6	Виртуал хөрөнгө	1	14	-	12

2022 оны III улирлын өргөдлийн судалгааны тайлан

7	Банкны үйл ажиллагаа	-	7	-	6
8	Үнэлгээ буруу хийсэн	-	3	-	3
9	Нэмэгдсэн өртгийн албан татвар	-	-	1	1
10	Гаалийн байгууллагын талаар	-	-	1	1
11	Ипотекийн зээлийн тухай	-	-	2	2
12	Жолооны курс	-	1		
	Нийт	22	41	7	47

График 11. Бусад ирсэн өргөдлийн хэлбэр



ХОЁР. АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

1.Хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянаж, хуульд заасан эрх хэмжээний хүрээнд урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хийж хувьцаа зөвшөөрөлгүй худалдсантай холбоотой гомдол гаргасан 2 иргэнд 51 сая төгрөг олгуулж, даатгалтай холбоотой 51 иргэн, хуулийн этгээдэд 541,801,114.78 төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулахаар урьдчилан шийдвэрлэснээс, даатгагч 24 иргэн, хуулийн этгээдэд 174,364,333.7 төгрөгийн нөхөн төлбөрийг олгуулсан.

2.Хөдөө орон нутаг болон аливаа шалтгааны улмаас өөрийн биеэр ирэх боломжгүй иргэдэд зориулж Хорооны цахим хуудсаар дамжуулан өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэж байна. /Цахим болон инфо/ <http://www.frc.mn/i/Feedback>

3.“Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах тухай” хуулийн төслийн ажлын хэсэгт ажиллаж байна.

4.Хороонд ирүүлсэн нийт өргөдөл гомдлын бүртгэл судалгааг зохицуулалтын салбар тус бүрээр тогтмол хөтөлж, мэдээллийн бааз үүсгэн ажиллаж байна.